



## **Утэ Кумпф**

Германы Бундестагийн гишүүн  
Бундестаг дахь ГСДН-ын бүлгийн менежер  
“Иргэний санаачлага” ажлын хэсгийн спикер

Зуны академи сургалт  
Фридрих-Эбертын-Сан

„ГСДН болон Герман улс дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо“

Улаанбаатар хот, 2009 оны 7 сарын 8

Уте Кумпф, Бундестагийн гишүүн

*„Хүнлэг ертөнцийг хүсвэл, эрэгтэй хүний ертөнцийг давах хэрэгтэй.“ (Хамбургийн хөтөлбөр)*

*„Бидэнд эмэгтэйчүүд тоон үзүүлэлтийн хувьд биш, улс төрд чухал хувь нэмэр оруулдагаараа хэрэгтэй.“ (Вилли Брандт)*

## **Тойм**

Эмэгтэйчүүдийн улс төрийн ажиллагааны зүгээс сүүлийн жилд хоёр чухал ойн баяр тэмдэглэгдсэн. Энэ нь: эмэгтэйчүүд сонгох эрхтэй болсны 90 жил (1918 оноос) болон эмэгтэйчүүдийн оролцоо буюу квотын 20 жил (1988) юм. Энэ онд манай улс Германы Үндсэн Хуулын 60 жилийн ойгоо тэмдэглэж байна. Энэ хуулиар анх удаагаа хүйсний ялгалгүй тэгш эрхийг үндсэн эрхээр хуульчлав. Эдгээр үйл явдлууд нь улс нийгмийн орчин үеийн шуудрага чиглэлэлийн дагуу хөгжих томоохон алхамуудыг тодорхойлов. Эмэгтэйчүүд нийгэм ба улс төрд тэгш эрхт байр суурь олохын тулд урт зам туулж ирсэнч эдүүгээ зорилгодоо бүрэн хүрээгүй байна. Энэ нь хүний эрхээс гадна эдийн засгийн ач холбогдолтой. Аливаа улс ардын аж ахуй нь мэргэжилтэй боловсон хүчний нөөцийг ашиглахын тулд тэднийг улс нийгмийн процесст хамруулан оролцуулах нь нэн чухал байдаг.

Энэ нь орчин үеийн биеэ даасан эмэгтэйчүүдийн амьдралд нийцэхгүй байна. Өнөөдрийн эмэгтэйчүүд амьдралаа өөрсдийн төсөөллөөр төлөвлөдөг. Иймд тэд сайн боловсрол болон мэргэжил эзэмшин, өөрийн гэсэн мөнгөтэй болж, олонхи нь хүүхэд төрүүлж, нийгэмд хариуцлагатай байр суурь олохыг хүсдэг [Жинжлэх Ухааны Төв Берлин (WZB) болон Хэрэглээний Нийгмийн Шинжлэх Ухааны Хүрээлэн (infas) хамтарсан 2008 оны БРИГИТТЕ-Судалгаа]. Улс төрчдийн томоохон сорилт нь үүний суурь нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. ГСДН нь эмэгтэйчүүдийн асуудалд хандсан анхны нам болсноороо гол хөдөлгүүр хүч нь юм.

**Герман Улсын эмэгтэйчүүдийн өнөөгийн нөхцөл байдал хэрхэн байна вэ?**

**Дараахи тоон үзүүлэлтээс үзнэ үү:**

## **Хүн амын тоо**

- Герман Улсын хүн амын **дийлэнхи** хувийг **эмэгтэйчүүд** эзэлдэг. 82.2 сая хүний 51% нь (41,9 сая) эмэгтэйчүүд болон охидууд байдаг.
- 2007 оны байдлаар, гадаад орнуудаас 7.5 сая эмэгтэйчүүд Герман улсад шилжин ирж суурьшсан байна. Тэдгээрийн 21% нь хуучнаар Зөвлөлт Холбоот Улсаас, 19% нь

Турк улсаас, 12% нь газар дундын тэнгисийн орнуудаас, мөн 11% нь Польш улсаас ирсэн байна.

### **Мэргэжил ба Боломж**

- **Их сургууль төгсөгчдийн тал** шахам хувь нь эмэгтэйчүүд байдаг. Хэлний болон соёл, урлагын ангийг (69.8%) төгсөгчид, хүмүүнлэг, анагаах ухааны ангийг (58.8%) төгсөгчдийн талаас илүү хувийг эмэгтэйчүүд эзэлдэг.
- 2005 оны байдлаар, нийт хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн тэн хагас нь аж ахуйн 87 салбараас зөвхөн 5 салбарт нь тухайлан ажилаж, ялангуяа ахуйн үйлчилгээлний болон нийгэм хангамжийн салбарт илүүтэй хөдөлмөрлөж байжээ. Тухайлбал, Оффисийн ажилтан/Эдийн засагч 19.9%, Эрүүл мэндийн салбарт 10.3%, Худалдаа 8% Нийгэм хангамжын салбар 6.8%, Цэвэрлэгээ болон хог хаягдал 5.8% тус тус байлаа.
- Герман Улсын хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийн тоо өсөж улмаар 64%-д хүрлээ. Гэвч хувийн хэвшил болон шинжлэх ухааны салбарын удирдах албан тушаал дээр эмэгтэйчүүдийн эзлэх хувь цөөн байдаг. Харин улс төрд эмэгтэйчүүдийн эзлэх хувь өсөж, Холбооны Канцлер болон парламентэд 6 эмэгтэй гишүүнтэй болсноор Герман улс Европын Холбооны улсууд дотроо 4-ээр байр эзлэх болсон.
- Жижиг дунд үйлдвэрийн доод болон дунд төвшний удирдах албан тушаал дээр эмэгтэйчүүд голлон ажилладаг. 2005 онд жижиг дунд үйлдвэрийг 1/5-ийг нь эмэгтэйчүүд удирдаж байсан. Үндэсний томоохон 50 компанийн тэргүүн буюу удирдах зөвлөлийн даргаар эмэгтэй хүн ажиллах нь онцгой тохиолдол юм.
- Эмэгтэйчүүдийн орлого эрэгтэйчүүдийнхээс доогуур байдаг: Герман улсад цалингийн ялгааны төвшин 23%-тай байна. Энэ нь дараах хүчин зүйлүүдээс хамааралтай. Жишээ нь, улс ардын аж ахуйн олон салбаруудад, мэргэжлийн олон ажилууд дээр эмэгтэйчүүдийн эзлэх хувь цөөн байдаг, гэр бүлийн амьдралын улмаас тэдний хөдөлмөр эрхлэлт завсардаж улмаар эрэгтэйчүүдтэй харьцуулахад хөдөлмөрийн бүтээмж нь мэдэгдэхүйц удаан болдог байна. Ихэнхдээ эмэгтэйчүүд ажилладаг салбарын цалин бага байдаг.

### **Эмэгтэйчүүдийн амьдралын хэв маяг**

- Германд Европын Холбооны Улсуудтай адил хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нь хүүхэдгүй эмэгтэйчүүдийнхээсээ илүү бага байдаг. Дани улсад эхчүүдийн 80% ажилладаг бол Германд эхчүүдийн ердөө 60% нь хөдөлмөр эрхлэдэг. Европын холбооны дундаж хэмжээ нь 64.5% юм.
- Эмэгтэйчүүдийн тэтгэвэр нь эрэгтэйчүүдээсээ дунджаар 475 еврогоор бага байна. 2006 онд эмэгтэйчүүдийн дундаж тэтгэвэр нь 509.18 евро байсан. Эрэгтэйчүүд сардаа дунджаар 984.18 евро тэтгэвэр авдаг.

- Эмэгтэй хүн эрэгтэй хүнтэй харьцуулахад **эрүүл мэнддээ илүүтэй анхаарал** тавьж амьдардаг: Эмэгтэйчүүдийн 78% нь огт тамхи татаж байгаагүй бол эрэгтэйчүүдийн 44% нь энэ үзүүлэлтэд багтана.

### Санаачлага ба Хамтран шийдвэрлэх

- **Сонгогчийн** хувьд эмэгтэйчүүд улс төрд **идэвхитэй** нөлөөлдөг. 2005 оны Бундестагийн сонгуульд 5 эмэгтэй тутмаас 4 нь (78%) оролцсон. Эрэгтэйчүүд сонгуульд 79%-тай оролцож ялимгүй илүү байсан.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн тавцанд эзлэх хувь нь хүн амын эзлэх хувьтай харьцуулхад бага байна. 1983 онд парламентын гишүүдийн 10-аас доош хувийг нь эмэгтэйчүүд эзэлж байсан бол өнөөдөр Бундестагийн 32 шахам хувийг бүрдүүлж байна. Харин орон нутгийн парламентэд илүү цөөхөн хувь эзэлж байна.
- Гэр бүл доторхи үүрэг хариуцлагын хувиарилалт нь тэгш бус хэвээр байна. Жишээ нь: гэрийхнийгээ асрах тохиолдолд. Эмэгтэйчүүд 7 хоногт 31 цаг, эрэгтэйчүүд 19.5 цаг цалингүй ажил эрхэлж байна.
- Өөрсдийн санаачилсан сайн дурын ажлаараа эмэгтэй болон эрэгтэйчүүдийн хувьд ялгаатай байдаг. Эрэгтэйчүүд илүүтэйгээр спортын салбар (14%), улс төр (4,5%) болон мэргэжлийн ашиг сонирхолын төлөөллийн газруудад (4%) сайн дураараа ажилладаг бол эмэгтэйчүүд нийгмийн (4%) болон сүм шашны (7%) салбарт идэвхи гаргадаг.
- 2005 оноос хойш (сонгуулийн 16-р үе) эмэгтэйчүүд ГСДН-ын парламентийн гишүүдийн **39%** -ийг, парламентийн нийт гишүүдийн 32%-ийг тус тус бүрдүүлж байна.
- **ГСДН-ын удирдах зөвлөлийн гишүүдийн 42.2%**-ийг эмэгтэйчүүд эзэлдэг бөгөөд **ГСДН-ын нийт гишүүдийн 30.3%** нь эмэгтэйчүүдээс бүрддэг.
- Дараахи хүснэгт нь эмэгтэйчүүдийн бусад намд эзлэх хувийг нь харуулав.

Функц	Германы Социал-демократ Нам	Ногоон Нам	Христосын Ардчилсан Холбоо Нам/ Христосын Социал Холбоо Нам	Чөлөөт Ардчилсан Нам
Намын гишүүн	30.3	34.3	23.3	23.6
Бундестагийн гишүүн	39.0	58.2	23.0	27.7
Удирдах	42.2	60.0	19.5	20.7

зөвлөлийн гишүүн				
---------------------	--	--	--	--

### **Өнгөрсөн тойм:**

#### **1869-1933: ГСДН нь тэгш эрхт нам бөгөөд эмэгтэйчүүдийн хөдөлгөөнийг анхны урсгалын дэмжигч нам**

ГСДН нь 1869 онд байгуулагдсан цагаасаа эхлэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн тэгш эрхийг хамгаалж ирсэн. Аугуст Бебель „Эмэгтэйчүүд ба Социализм“ (1897) зохиол болон эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэлийн онолоороо гол суурийг нь тавьсан. „Нийгмийн хараат бус байдал болон жендерийн тэгш эрхт байдалгүйгээр хүн төрлөхтнийг аврах боломжгүй“ (1897) гэсэн гол агуулга нь өнөөг хүртэл хүчин төгөлдөр байна.

ГСДН ба улс төрийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлсэн үе шатууд:

- **1890 онд** эмэгтэйчүүд өөрсдийн төлөөлөгчдийг намын их хуралд ороцуулж болохыг намын дүрэмд баталсан билээ. Энэ нь ширүүн маргаантай байв.
- **1907 онд** миний сонгуулийн тойрог Штуттгарт хотод анхны олон улсын социалист эмэгтэйчүүдийн бага хурал болсон.
- **1908 онд** эмэгтэйчүүдийг улс төрийн цуглаан хийх ба улс төрийн холбоо байгуулж болох эрхийг Рейхийн Холбооны шинэ хуулиар баталсан. Тэр ондоо ГСДН нь эмэгтэй гишүүдийнхээ тоонд тохируулан удирдах зөвлөлдөө эзлэх хувийг нь нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.
- **1911 онд** 45000 эмэгтэйчүүд „Эмэгтэйчүүдийн сонгох эрхийг өг“ мөн нэг төрлийн ажилд ижил цалин олгох ба хөдөлмөр болон эрүүл мэндийн хамгаалалтыг сайжруулах шаардлагуудыг тавьсан.
- **1918 онд** эмэгтэйчүүдийн идэвхитэй болон идэвхигүй оролцох сонгуулийн хуулийг баталсан.

- **1919 онд** эмэгтэйчүүд анх удаа сонгуульд саналаа өгөх болов. Парламентад 9.8% -ийг нь эмэгтэйчүүд эзэлж байв. Мари Юхач ГСДН-аас парламентад анхны эмэгтэй гишүүнээр сонгогдож, ГСДН-ын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан гишүүн болов.
- **1925 онд** эмэгтэй болон эрэгтэйчүүдийн нам доторхи функцийн хувиарлалт нь намын гишүүнчлэлийн дагуу хийгдэж, ГСДН-ын дүрэмд тусгагдан орж, улмаар 1946 онд ГСДН-ын дахин байгуулалтаар сэргээгдэв.

Ваймарын Бүгд Найрамдах Улсын „Алтан хорьтын эрин“-ийн үеэр эмэгтэйчүүд ялангуяа хотуудар урьд нь үзээгүй хэмжээний соёлын болон нийгмийн эрх чөлөө олсон. Дэлхийн эдийн засгийн хямрал ба национал-социализмын үеэр эмэгтэйчүүдийн хөдөлгөөний анхны урсгалын олон ололтуудыг үгүй болгосон.

### **1945-1979: Нийгмийн үнэлэмжийн өөрчлөлт, хууль тогтоомжийн зохицуулалт ба эмэгтэйчүүдийн хөдөлгөөний хоёрдахь урсгал**

Дэлхийн 2-р дайны үед сая сая эрчүүд амь насаа алдан дайны олзлогсад болсон.

Герман орны сэргээн босголтын ихэнхи хувийг эмэгтэйчүүд гардан авч, гэр бүлээ авран улмаар улам их биеэ даасан.

1960-д оноос эхлэн барууны орнуудын оюутнууд нийгмийн нөхцөл байдлын эсрэг боссон. Шинэ Зүүний урсгал үүссэн. Үүнтэй уялдан эмэгтэйчүүдийн автономит хөдөлгөөн бие болж, чухал болон хориг цээртэй сэдвүүдээр олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг явуулав. Энэ хөдөлгөөн нь улс төрийн хэмжээнд эмэгтэйчүүдийн асуудалд илүү анхаарал тавьхад хүргэсэн. ГСДН-ын удирдлагын дор эмэгтэйчүүдийн амьдралын болон хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулсан мөн тэднийг ялгах явдлыг арилгах чухал хуулиуд батлагдсан.

### **1949: Үндсэн хууль батлах**

Үндсэн хууль боловсруулахад дөрвөн эмэгтэй оролцож, тэдний дунд ГСДН-ын хоёр эмэгтэй (Др. Елизабет Селберт ба Фридерике Надиг) ажилласан. Анх удаагаа жендерийн тэгш эрхийг үндсэн хуулиар баталсан. Тэгш эрхийн талаар 3-р зүйлийн 2-р хэсэгт ийнхүү өгүүлсэн байдаг:

*„Эрэгтэй болон эмэгтэйчүүд тэгш эрхтэй. Төр эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн тэгш эрхийг бодитоор хэрэгжүүлж, муу талуудыг нь арилгахад үр нөлөөгөө үзүүлнэ.“*

### **1949: Анхны Германы Бундестаг**

1949 оны анхны Парламентад 28 эмэгтэй төлөөлж байсан, энэ нь нийт парламентын гишүүдийн 6.8%-ийг эзэлж байлаа.

**1957/58:** Үндсэн Хуулийн заалтын дагуу Иргэний Эрхийн Хуулинд дахь тэгш эрхт байдлыг **Тэгш Эрхийн Хуулиар** хэрэгжүүлэх болсон. Тэр үед чухал асуудлуудыг гэр бүл бологсдын ба айл өрхийн тухай хуулинд тусгаагүй. Жишээ нь, гэрлэсэн эмэгтэй зөвхөн нөхөр нь зөвшөөрөх тохиолдолд ажилладаг байсан. Үүний зэрэгцээ, эхнэр болон гэр бүлийнхээ үүргийг биелүүлэх шаардлагатай байжээ.

### **1972: Социалдемократ эмэгтэйчүүдийн ажлын холбооны (АСФ) үндэслэн байгуулалт**

Бид, ГСДН-ын эмэгтэйчүүд, өөрийн ашиг сонирхолын төлөөллийг шаардан, 1972 онд намын эмэгтэй болон эрэгтэй байнгын гишүүдийн эсэргүүцлийг даван Социалдемократ эмэгтэйчүүдийн ажлын холбоог (товч АСФ) байгуулсан юм. АСФ нь намтай ижил бүтэцтэй бөгөөд ардчилсан дүрэмд хөтлөгддөг. Үүнд: дотроосоо сонгосон удирдах зөвлөл, өөрсдийн баталсан мөрийн хөтөлбөр мөн бие даасан улс төрийн үзэл баримтлал орно. Зорилго нь: оролцоо болон жендерийн тэгш эрхт байдлын үзэл санааг намын бодлогод нэвтрүүлнэ.

**1976/77: Гэр бүл бологсдын ба айл өрхийн тухай хууль** болон **овог нэрийн тухай хуулын шинэчлэлтээр** гэр бүл бологсдын ба айл өрхийн тэгш эрхт байдлыг тогтоов. Энэхүү хуулийн шинэчлэлтээр эмэгтэйчүүдийг гэр орны ажил хийх хуулийн үүргээс чөлөөлсөн. **Гэрлэлт цуцлах тухай шинэ хуулинд** тухайн гэрлэлтээ цуцлах гэр бүлийн цуцлах зарчим нь буруутай байх зарчмын урд орж, гэрлэгчдийн цуцлалтын дараах тэтгэмж олголтыг зохицуулдаг.

### **1977: „ГСДН-ын доторхи тэгш эрхт байдал“ ажлын бүлгийн үйл ажиллагаа**

„ГСДН-ын доторхи тэгш эрхт байдал“ ажлын бүлэг нь 1977 онд гишүүдийн тэнцвэртэй бүрэлдэхүүнтэй тэр үеийн намын дарга Виллигийн дэмжлэгтэйгээр байгуулагдаж, намын дарга болон АСФ-ын дарга гэсэн тэгш эрхтэй хоёр даргын удирдлага нь дор байсан. Энэхүү бүлэгийн үүрэг даалгавар нь намын доторхи эмэгтэй ба эрэгтэй хүний тэгш эрхт байдалыг бий болгоход оршиж байсан. Тэр ондоо уг ажлын бүлэг нь санал бологосон квот буюу эмэгтэйчүүдийн оролцооны хувийг нь нийт гишүүдийн дотор эзлэх хувьтай нь тэнцуулэх талаар хэлэлцэв.

### **1979: Берлиний намын их хурлаар баталсан тэгш эрхт байдалын тухай тогтоол**

*„Эмэгтэй хүний тэгш эрхт байдал нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүд хамтарч шийдвэрлэх нийгмийн асуудал юм. Түүний амжилт нь шаардлагатай бодол санааны хувиралтын процесийг эхлүүлж улмаар нийгмийн ухамсарт өөрчлөлт оруулж чадах эсэхээс хамаарна.“ [...] „ГСДН нь өөрийн эгнээндээ эмэгтэйчүүдийн тэгш эрхт байдлыг бодитоор хэрэгжүүлсэн цагт, энэхүү бодлогыг үнэн ёсоор нь төлөөлөх болно.“*

### **Квотын тогтоол**

**1988 онд** ГСДН-ын Холбооны их хурал дээр удаан хугацаанд үргэлжилсэн ширүүн мэтгэлцээний үр дүнд **эмэгтэй ба эрэгтэйчүүдийн сонгуулийн оролцооны баталгаат доод хэмжээг (квот)** тогтоосон. Өнөөдрийг болтол **ГСДН нь дотоод дүрмэндээ** „функц болон мандатад эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүд 40% дээш хувийн оролцоотой" байхыг заасан байдаг. Орон нутгийн ба холбооны муж улсын сонгуульд намын хэмжээнд дахь эмэгтэйчүүд ба эрэгтэйчүүдийн оролцооны хувь чөлөөтэй байдаг бол, ГСДН-ын Бундестагийн сонгуульд оролцох дүрмэнд хязгаар заасан байдаг. 4-р зүйлийн 2-р хэсэгт ийнхүү өгүүлсэн байдаг:

*„сонгуульд оролцох нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг солбих зарчмаар гаргана; хамгийн олон санал авах магадлалтай эрэгтэй буюу эмэгтэй нэр дэвшигчээр эхлэн эмэгтэй, эрэгтэй солбин 5-р эгнээнд нэг бол эмэгтэй юмуу эрэгтэй нэр дэвшигч бичигддэг.“*

### **Бусад намын квот**

- 1996 оны **ГСДН**-ын их хурлаар эмэгтэйчүүдийн оролцооны сайн дурын квотын системийг ГСДН-ын дүрмээр баталж, үүнд эхний сонголтын явцад эмэгтэйчүүдийг бүхийл албан тушаал, мандат болон функц нд 1/3 оролцоотой байхыг заасан. Давтан сонголт явуулах болсон тохиолдолд дээрхи квотын дүрэм нь хүчингүй болно.
- **Ногоон Намын** дүрэмийн дагуу эмэгтэйчүүд уг намын Холбооны бүхийл зөвлөл болон байгуулагуудад 50 хувиас дээш хэмжээний оролцоотой байхыг шаарддаг.
- **Чөлөөт Ардчилсан Нам** нь эмэгтэйчүүдийг нам дотроо квотын аргаар дэмжихээс татгалздаг. Холбооны удирдах зөвлөлийн 1987 оны шийдвэрээр эмэгтэйчүүдийн тэгш эрхт байдлыг намын байгуулагуудын бүхийл үе шатанд сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэхийг заасан. Чөлөөт Ардчилсан Нам нь эмэгтэйчүүдийн



шийдвэрлэх албанд эзлэх хувийг нь нийт гишүүдийн дотор байгаа хувьтай нь тэнцуулэхийг эрмэлзэж байна.

- **Зүүний Нам** нь дүрмэндээ парламентын зөвлөлийн болон намын бүх албан тушаалын сонгуульд нэр дэвших эмэгтэйчүүдийн оролцооны хувийг 50 дээш хэмжээгээр тогтоосон.
- **1994 оны Бундестагийн сонгуулиар** (сонгуулийн 16-р үе) нэр дэвшихэд ГСДН-ын хувьд анхны удаа квотын систем үйлчилсэн. Эхэнд дурьдсанчлан, **2005** оноос хойш (сонгуулийн 16-р үе) **ГСДН-ын парламентийн гишүүдийн 39%** -ийг **эмэгтэйчүүд эзэлдэг** бөгөөд парламентийн нийт гишүүдийн **32%**-ийг бүрдүүлж байна.

### **Квот дангаараа хангалтгүй – агуулга нь чухал**

Эмэгтэйчүүд дангаараа хөтөлбөрийг бүрдүүлж чадахгүй. Энэ нь эмэгтэйчүүд бидний хувьд квотын системд орох явцад зайлшгүй байх мэдээжийн зүйл юм. Квот нь улс төр, нийгэм болон эдийн засагт тэгш эрхт байдлыг хэрэгжүүлэх нийт бодлогын хэрэгсэл болж, бидэнд **үзэл бодлоо** болон ашиг сонирхолоо илэрхийлэх боломжийг олгож байгаа юм. Эмэгтэйчүүд өөрийн мэргэжлийн өндөр чадвар болон туршлагаасаа олж авсан мэдлэгээ улс төр болон нийгмийн тогтолцоог хөгжүүлэхэд зориулах нь зүйтэй. Тийм учраас **хөтөлбөрийн чухал ажлуудыг** дараахи сэдвүүдээр хийж ирсэн ба хийсээр байна:

- Боловсрол болон мэргэжил эзэмших ижил боломж
- Нэг төрлийн ажилд ижил цалин олгох
- Гэр бүлийн амьдрал болон хөдөлмөр эрхлэлтийн зохицол (хүүхдийн асрамж, эх эцэг ажилаасаа чөлөө аван хүүхдээ гэртээ асрах цаг, 10-н жилийн бүтэн өдрийн сургалттай сургууль)
- Тэгш эрхт байдлыг эрхэмлэсэн гэр бүлийн бодлого
- Нийгмийн баталгаа, нийгмийн баталгааны системд тэгш эрхийг эрхэмлэх
- Эмэгтэйчүүд шинжлэх ухаан ба боловсролын салбарт
- Эмэгтэйчүүдийн эруул мэнд ба эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл

2007 оны 10 сарын ГСДН-ын Хамбургийн Хөтөлбөрт хуулиар олгогдсон тэгш эрхийг бодит байдалд хэрэгжээгүйг тогтоосон. ГСДН нь „эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн амьжиргааны баталгааг хангах ажлын тэгш эрхт болон шуудрага оролцооны төлөө тэмцсээр байна“ (Хамбургийн Хөтөлбөр, 41-р хуудас). Үүний тулд хүүхдийн асрамжийг хөгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай байна. „Нэг төрлийн ажилд ижил цалин олгоно“ гэсэн зарчимд хөтөлөгдөн, ГСДН нь боловсролын түвшин ижилтэй эмэгтэй болон эрэгтэйчүүдэд адил хэмжээний цалин олгохын төлөө тэмцсэн хэвээр байна.

## **„Мэргэшсэн эмэгтэй боловсун хүчин олдохгүй байна“ гэсэн атгаг санааны эсрэг тэмцэл**

Квотын хэлэлцүүлгийн үеэр „янз бүрийн албан тушаал дээр тохирох мэргэшсэн эмэгтэй боловсон хүчин олдохгүй байна ...“ гэсэн яриа дахин дахин гарч байсан. Үнэн хэрэг дээр охид эмэгтэйчүүд Герман Улсын их, дээд сургуулиудын нийт төгсөгчдийн 48%-ийг эзэлж, эрэгтэйчүүдтэй мөр зэрэгцэн яваа. 2008 оны (техник мэргэжлийн) гимнази төгсөгчдийн 53.5% нь эмэгтэйчүүд байсан тоо баримтаас үзэхэд, ирээдүйд энэ хандлага өсөх төлөвтэй байгааг харуулж байна.

Түүнчлэн ГСДН-ын ердөө 31% нь эмэгтэйчүүд байдаг нь мөн бодит үзүүлэлтийн нэг юм. Ингээд бид эмэгтэйчүүдийг улс төр болон ГСДН-ын ажилд татан оруулах үүрэгтэй. ГСДН нь өөрийнхөө ажлыг эмэгтэйчүүдийн амьдралын нөхцөл байдалд нийцүүлэх нь зүйтэй. Амжилтанд хүргэх нэг боломж нь **Менторинг-Хөтөлбөрүүд** юм. Жишээ нь, Социалдемократ эмэгтэйчүүдийн ажлын холбооны (АСФ) Менторинг-Хөтөлбөр байдаг. Уг хөтөлбөр нь дараахи зорилготой:

- идэвхитэй залуу эмэгтэйчүүдийг нам болон холбооны ажилд дэмжих
- удирдах албан тушаал дээрхи эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэн дэмжих
- эмэгтэйчүүдийн сүлжээг хөгжүүлэх
- нам болон холбоон доторхи эмэгтэйчүүдийн диалогийг бэхжүүлэх.

Эмэгтэйчүүд эрх мэдлээс айдаг цаг үе өнгөрсөн. Жишээ нь: Ангела Меркел, Хиллари Клинтон, Хайдемари-Вичорек-Цойл, Сежелзон Рояал мөн европын болон дэлхийн олон эмэгтэйчүүдийг нэрлэж болно. Бидний эрх мэдэлд хүрэх замын чухал зүйл нь хоорондын сүлжээ юм. Бидний хувьд дан ганцаараа карьер хийх нь чухал бус. Бид **хоорондын сүлжээгээгээ** хөгжүүлж, эмэгтэйчүүдгүй үлс орон оршин тогтнох боломжгүйг ойлгосон эрэгтэйчүүдийг холбоотонгоо болгох нь чухал юм.

## **4. Улс төрийн сорилт**

Бидний тэгш эрхт байдлын төлөөхи тэмцэл нь ахицтай байгаа боловч эртний хувирилалт бүр мөсөн арилаагүй байна. Одоогоор хуулиар олгогдсон тэгш эрхийг бодит байдалд хэрэгжинэ гэсэн баталгаа байхгүй байна. Эмэгтэйчүүдийн улс төрийн бодлогыг өөрсдөө хэрэгжүүлж байгаа зүгээс нь хархад, дараахи „барилгын талбайд“ чиглүүлэх нь урьдын адил шаардлагатай хэвээр байна. Үүнд:

### **Цалингийн тэнцвэр**

Ялангуяа **хөдөлмөрийн салбарт** эртнээс үүссэн цалингийн ялгаа нь хэвээр байсаар байна. Эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй адил түвшинд мэргэшсэн боловч хэд дахин багаар цалинждаг. Статистикийн мэдээнээс үзэхэд эмэгтэй болон эрэгтэй хүний цалингийн ялгаа нь 20%-30% хооронд хэлбэлзэж байдаг.

### **Эмэгтэйчүүд удирдах албанд**

Нийгмийн болон эдийн засгийн салбарын гол албан тушаалууд дээр ихэнхдээ эрэгтэйчүүд ажилладаг. Томоохон компаниудийн удирдах албан тушаалд ердөө 4%-ийг нь эмэгтэйчүүд эзэлдэг. Европ дахь хөрш Норвеги улсыг авч үзэхэд, зүгээр амлахын оронд хуулийн зохицуулалтаар өөрчлөлт оруулах боломжтой нь харагдаж байна. Норвеги улс нь биржэд бүртгэлтэй компаниудийн удирдах зөвлөл болон төлөөлөн удирдах зөвлөлийн 40 дээш хувь нь эмэгтэйчүүд байхыг шаарддаг. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд аж ахуйн нэгжид хориг тавьж, албадан хаалгуулахад хүрдэг.

### **Гэр бүл болон ажил албаны уялдааны сайжруулалт**

Залуучуудын 90% нь хүүхэдтэй амьдралыг хүсдэг. Гэвч эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн хүүхэдгүй амьдрах хандлага нь нэмэгдсээр байна. Тэдний дийлэнхи нь өндөр боловсрол болон цалинтай байдаг. Нөгөөтэйгүүр, эхчүүд хусээгүй боловч хөдөлмөр эрхлэлтээс татгалзах болдог. Иймд, хүүхдийн асрамж мөн боловсролын салбарын үйлчилгээ, чанарыг нь сайжруулж, өрхүүдэд санхүүгийн туслалцаа, гэр бүлүүдэд ээлтэй ажлын нөхцөл бүрдүүлж нөхцөл байдлыг нь өөрчлөх шаардлагатай байна.

### **Жендерийн тэгш эрхийг эрхэмлэсэн татварын тогтолцоо**

Германы татварын тогтолцоонд гэр бүлийн „ганцаараа цалинжигчийн“ загварыг дэмжсээр ирлээ. Үүнд гэр бүлийн нэг нь (ихэнхдээ нөхөр нь) хөдөлмөрлөн орлого олж, нөгөө нь гэртээ суудаг. Энэ нь эмэгтэйчүүд өөрсдөө хөдөлмөр эрхлэх сонирхолыг нь буруулхад хүргэдэг.

### **Дүгнэлт**

Герман улсад ч мөн шийдвэрлэж хэрэгжүүлэх асуудал их байна. Гэсэн ч, эмэгтэйчүүдийн нийгэм, улс төрийн оролцоог дээшлүүлэх тэмцэл нь өгөөжөө өгдөг. Улс төр, нийгэм болон эдийн засагт эмэгтэйчүүд их хэмжээний хувь нэмэр оруулж чадна. Манай анхны эмэгтэй сайдуудын нэгэн Кэте Штробель (1907-1996) хэлсэнчлэн „Улс төрийг зөвхөн эрэгтэйчүүдэд даалгана гэхэд хэтэрхий чухал зүйл юм.“